

ИВОЛГИЙН ДАЦАНЫ ТҮҮХЭН ТОЙМООС

Х.Мандухай*

*ОУСХ-ийн Орос судлалын секторын ЭША

Энэ зун наймдугаар сард миний бие Буриадын Улаан-Үүд хотод байрладаг Иволгийн дацан үзэж, Итгэлт хамбын ариун шүтээнд мөргөх сайхан завшаан тохиож билээ. Маш цэвэр цэмцгэр, ариун дагшин энэ газарт энэ гайхамшигт дацан сүндэрлэн, шүтэн бишрэгч үй олныг хүлээн авч, мөргөл үйлдүүлдэг бурхан шашны томоохон төв болжээ. Ингээд энд олж мэдсэн, уг дацаны үүх түүхээс товч авч өгүүлэхийг хичээлээ.

Иволгийн дацанг 1946 онд анх сэргээн босгосон бөгөөд Пандит Хамба ламын гуравдахь харш орд аж. Уг дацан Оросын Холбооны улс дахь Буддизмын түүхэнд чухал байр суурь эзэлдэг байна.

Оросын нутаг дэвсгэрт Буддизм анх XVI-XVII зуунд дэлгэрч тархсан түүхтэй юм байна. Тэр нь гол төлөв монгол туургатан-буриад, Халимаг, Туваачуудын дотор үүсэж хөгжиж эхлэсэн байна. 1741 онд хатан хаан П.Елизаветын зарлигаар буддизм нь Оросын уламжлалт шашины нэг мөн хэмээн хүлээн зөвшөөрөгджээ. Энэ үеэс Оросын эзэнт гүрэнд Бурханы шашин (Буддизм)-ын сүм хийд, төвүүд эрчимтэй бүрэлдэж бий болсон байна.

Оросын эзэн хааны зарлигийн үндсэн заалтын дагуу 1853 оноос Байгалийн чанадад Бурха шашины төвийн тэргүүн томилогдон, бүтэц зохион байгуулалтын хувьд бэхжих болжээ. Чухамхүү энэ үеэс Пандит Хамба лам тэргүүлсэн бурхан шашны байгууллын нэгж бий болсон байна. XIX зууны төгсгөл үе гэхэд Буддизм Буриад түмний үзэл санаанд гүнзгий нэвтэрч нөлөөлөхүйц шашин ба улс төрийн том хүчин болж, зохион байгуулалтын хувьд бэхжиж эхлэжээ.

XIX зууны эцэс XX зууны эхэн үе бол Буриад Буддизмын үзэл санааны өсөлт цэцэглэлтийн үе байлаа. Пандит Хамба ламын идэвхитэй, алсын чиг зорилго бүхий үйл ажиллагааны үр дүнд Буриадын бурхан шашины төвлөрсөн сүм дуганууд бий болж, нэгдмэл удирлагатай нэгдсэн бүтцүүд зохион байгуулагджээ. Түүнчлэн энэ үед Бурхан шашины төв болох сүм хийдүүд эдийн засгийн хувьд сүрхий хүчирхэгжиж бэхжсэн

байна. Тийнхүү Бурхан шашины сүм хийдүүд Буриадын нийгмийн чухал нэгэн хэсэг нь болж, цаашдын хөгжилд нь ихаахан нөлөө үзүүлжээ. XX зууны 30-40-өөд оны үе бол Буриад Буддизмын түүхэнд онцгой хүнд үе болсон байна. Олон тооны сүм хийдийг хүчээр хааж, галдан шатааж устгаж лам хуврагуудыг хөөн тарааж, бөөнөөр нь баривчлан хорьж цагдаж эхлэсэн байна. Бурхан шашины эсрэг ийм зэрлэг, балмад харгислалын явцад улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 47 томоохон сүм хийд, дацанаас нэг нь ч үлдээгүй аж. Харин 1941-1945 оны Аугаа эх орны дайны ялалтаар дээрх хүнд байдал өөрчлөгдөх сайн цагийн бүлээн уур амьсгал ирэх болжээ. Буриад орон даяар Бурханы үзэл санааг сэргээн дэлгэрүүлэх, иргэдийн тахин шүтэх эрх чөлөөг зөвшөөрөх талын үүсгэл санаачлага, хөдөлгөөн өрнөж, зөвлөлт төр засгийн дээд удирдлагад санал хүсэлт удаа дараа тавьж байсны үрээр Дундад Иволга хэмээх хөдөө тосгонд нэгэн сүм байгуулж нээх шийдвэр гарчээ. Энэ шийдэл улам газар авч, ойр хавийн зэргэлдээ гацаа тосгод зэрэг бусад хөдөөгийн иргэдийн идэвхи зүтгэл, санаачлага дэмжлэг хүч түрэн гарч иржээ. Энэ бүхний ач буянаар Бурханы номтой иргэд, урьд өмнө нь лам хуврага явсан хүмүүс нэгдэн “Хамбын зөвлөл” байгуулж, түүнийг нэртэй лам Лувсан Нима Дармаев тэргүүлэх болжээ. “Хамбын зөвлөлийн” хүрээлэл улам бүр өргөжин тэлж, Бурханы үзэл санааг сэргээн дэлгэрүүлэх их ажил өрнөсөн байна. Чухамхүү энэ үед, тухайлан 1945 оны 12 дугаар сарын 12-ний өлзий буян дэлгэрсэн энэ өдөр Дэд Хамба лам Хайдан Галсанов тэргүүтэй бүх лам хуврагууд “Сахиусын хурал”-ыг анх удаа нийтэд ил нээлттэй хуржээ.

1927 онд жанч халсан Буриадын хамба лам Дашдорж Итгэлтийн цогцсыг газрын гүнд 1,5 метрт бунхлан үлдээж, 75 жилийн дараа буюу 2002 онд эргүүлэн Иволгийн дацанд залсан байдаг. Хамбын цогцос өдгөөг хүртэл огт муудааггүй яг л амьд хvнийх шиг байдаг гэж эмнэлгийн мэргэжилтнүүд үздэг юм. Хамба лам Улаан-Үдээс холгүй орших газар йогийн лянхуа суудлаар сууж бясалгал хийж байгаад өөд болсон ба ламтан өөрийн бунхныг тодорхой хугацааны дараа нээж vзэж байхыг гэрээсэлсэн аж. 2002 оны есдvгээр сарын 11-нд ламтны цогцсыг бунхнаас нь гаргаж, шинжээчид хамбын vс, хумснаас дээж авч шинжилгээ хийхэд тvvний арьс нь зөөлхөн, яг амьд хvнийх шиг байснаас гадна бие нь vээрээ нугарч, эд эсийн шинжилгээ нь амьд хvнийхтэй адилавар гарсан нь ихэд гайхашруулж байсан байна. Бурхны шашинтнуудын ярьж буйгаар йогийг бvрэн эзэмшсэн хутагт хувилгаад жанч халахаасаа өмнө өөрийн биеийг ариутган муудахааргvй болгодог гэж үздэг юм байна.

Чингэж Иволгийн дацаны анхны эх суурь “Хамбын сүм” нэртэйгээр тавигдсанаар Бурхан багшийн үзэл санаа дэлгэрэн мандах ариун үйл хэрэг эхлэсэн түүхтэй билээ.

Итгэлт хамбын тухай итгэмээргүй, гайхалтай олон яриа сонсогддогийн дотор түүнд мөргөн залбирсан олон хүн эрүүл саруул болж, хүсэл зорилго нь биелсэн гэдэг.

Итгэлт хамба дээр Оросын ерөнхийлөгчөөс авахуулаад ОХУ-ын олон улс төрийн зүтгэлтнүүд, одод, нэр хүндтэй хүмүүс очиж мөргөдөг аж. Оросын ерөнхийлөгч В.Путин болон экс ерөнхийлөгч Д.Медведев, Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, БНХалмиаг Улсын ерөнхийлөгч К.Илюмжинов гээд томчууд Итгэлт хамбад очиж мөргөл үйлджээ. Украины ерөнхий сайд Юрий Ехануров Итгэлт хамбад мөргөснийхөө дараа нь ерөнхий сайд болж, ОХУ-ын Дотоод Хэргийн сайд Рашид Нургалиев гэгээнтэн дээр очсоныхоо дараа сайд болов. Харин ОХУ-ын Засгийн газрын 7 сайд Итгэлт хамбад мөргөснийхөө дараа сайд болцгоосон байна.

Оросын Тэргүүн Шадар сайд байсан Анатолий Чубайсын машиныг дэлбэлэхэд тэрээр дотор нь сууж байсан ч амьд үлджээ. Халдлагын дараа Чубайс хамгийн түрүүнд Итгэлт хамба миний нүдэнд үзэгдсэн, тэрээр миний амийг аварсан гэж Халимагийн ерөнхийлөгч Илюмжиновт хэлсэн байдаг. Оросын Батлан Хамгаалахын сайд Сергей Иванов Иволгийн дацанд очоод “Итгэлт Хамба Орос Орны амгалан тайван байдлыг хамгаалж байна” гэжээ.

Итгэлт Хамбад мөргөсөн хүн гэнэтийн осолд ордоггүй гэж тахилч лам Бимбаа бидэнд хэлсэн юм. Ямартаа ч Эрдэнэт гэгээн Итгэлт хамба хүн төрөлхтөний сайн сайхны төлөө, өөрт нь ирж мөргөсөн хэний ч төлөө буян үйлдэхээр энэ хорвоод буцаж морилсон гэдэгт итгэнэм.

Ашигласан материал:

1. www.datsan.buryatia.ru
2. egov-buryatia.ru/index.php?id=372
3. Резиденция Пандито Хамбо Лам. 2006 он хх 0,6